| 113004 | 3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар | 68,758,500.00 | 62,938,060.00 |
| 118 | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 84,797,400.00 | 195,299,574.00 |
| 1180 | 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 8,817,400.00 | 17,801,100.00 |
| 118001 | 3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж | 4,097,400.00 | 1,356,100.00 |
| 118006 | 3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 2,000,000.00 | 13,541,000.00 |
| 118009 | 3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 2,720,000.00 | 2,904,000.00 |
| 1181 | 3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр | 75,500,000.00 | 177,498,474.00 |
| 118101 | 3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр | 75,500,000.00 | 177,498,474.00 |
| 1182 | 3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 480,000.00 | - |
| 118203 | 3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 480,000.00 | - |
| 12 | 3.1.01.1.2 Татварын бус орлого | 1,779,002,000.00 | 1,817,374,995.50 |
| 120 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 397,800,000.00 | 444,172,995.50 |
| 120003 | 3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого | 128,000,000.00 | 108,110,687.00 |
| 120004 | 3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 116,800,000.00 | 335,977,308.50 |
| 120010 | 3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 153,000,000.00 | - |
| 120009 | 3.1.01.1.2.1.9 Бусад орлого | - | 85,000.00 |
| 122 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 1,381,202,000.00 | 1,373,202,000.00 |
| 122003 | 3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас | 901,896,000.00 | 901,896,000.00 |
| 123 | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 479,306,000.00 | 471,306,000.00 |
| 123002 | 3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 479,306,000.00 | 471,306,000.00 |
| II | 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,000,751,100.00 | 2,612,465,109.48 |
| 21 | 3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 2,040,501,900.00 | 1,866,868,438.18 |
| 210 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,036,501,900.00 | 1,866,868,438.18 |
| 2101 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,008,075,200.00 | 957,084,594.00 |
| 210101 | 3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин | 931,053,200.00 | 529,564,611.00 |
| 210102 | 3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл | - | 344,186,488.00 |
| 210104 | 3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал | 31,482,000.00 | 37,834,340.00 |
| 210105 | 3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс | 45,540,000.00 | 45,499,155.00 |
| 2102 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 126,009,400.00 | 119,808,467.17 |
| 210201 | 3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал | 85,686,500.00 | 81,800,097.41 |
| 210202 | 3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал | 10,080,700.00 | 9,502,612.79 |
| 210203 | 3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал | 5,040,400.00 | 4,825,977.10 |
| 210204 | 3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал | 5,040,400.00 | 4,705,766.50 |
| 210205 | 3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал | 20,161,400.00 | 18,974,013.37 |
| 2103 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 626,881,700.00 | 612,328,977.01 |
| 210301 | 3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан | 77,705,500.00 | 44,962,960.94 |
| 210302 | 3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт | 537,767,200.00 | 560,081,896.42 |
| 210303 | 3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус | 11,409,000.00 | 7,284,119.65 |
| 2104 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 41,628,100.00 | 23,327,740.00 |
| 210401 | 3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг | 5,263,400.00 | 2,714,500.00 |
| 210402 | 3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун | 31,815,700.00 | 18,606,740.00 |
| 210403 | 3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,208,000.00 | 1,752,300.00 |

| | | | |
|--------|--|------------------|------------------|
| 210405 | 3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000.00 | 73,200.00 |
| 210406 | 3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 891,000.00 | 181,000.00 |
| 2105 | 3.1.01.2.1.1.5 Нормативт зардал | 414,000.00 | - |
| 210503 | 3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл | 414,000.00 | - |
| 2106 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 136,858,700.00 | 97,898,950.00 |
| 210601 | 3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл | 2,520,000.00 | - |
| 210604 | 3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар | 134,338,700.00 | 97,898,950.00 |
| 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 9,755,600.00 | 6,990,000.00 |
| 210702 | 3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт | 9,755,600.00 | 6,990,000.00 |
| 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,584,100.00 | 8,037,810.00 |
| 210801 | 3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,145,100.00 | 1,165,500.00 |
| 210802 | 3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 564,000.00 | 288,000.00 |
| 210803 | 3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ | 420,000.00 | - |
| 210804 | 3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар | 475,000.00 | 133,896.00 |
| 210805 | 3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо | 510,000.00 | - |
| 210806 | 3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,470,000.00 | 5,587,500.00 |
| 210807 | 3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр | 1,000,000.00 | 862,914.00 |
| 2109 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 70,295,100.00 | 41,391,900.00 |
| 210901 | 3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал | 51,399,100.00 | 28,526,000.00 |
| 210902 | 3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,896,000.00 | 12,865,900.00 |
| 213 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,000,000.00 | |
| 2132 | 3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 4,000,000.00 | |
| 213209 | 3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | |
| 22 | 3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 790,249,200.00 | 675,596,671.30 |
| 223001 | 3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө | 790,249,200.00 | 675,596,671.30 |
| 23 | 3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 170,000,000.00 | 70,000,000.00 |
| 230001 | 3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл | 170,000,000.00 | 70,000,000.00 |
| 8 | 3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | (441,740,500.00) | 145,632,908.24 |
| 9 | 3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 441,740,500.00 | (145,632,908.24) |
| 7 | 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 441,740,500.00 | (145,632,908.24) |
| 4 | 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 597,231,825.59 |
| 5 | 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 760,864,733.83 |
| 6 | 6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 68.00 | 68.00 |
| 61 | 6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2.00 | 2.00 |
| 610001 | 6.1.01 Төсвийн байгууллага | 2.00 | 2.00 |
| 62 | 6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО | 33.00 | 33.00 |
| 620001 | 6.2.01 Удирдах ажилтан | 10.00 | 10.00 |
| 620002 | 6.2.02 Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 10.00 |
| 620003 | 6.2.03 Үйлчлэх ажилтан | 3.00 | 8.00 |
| 620004 | 6.2.04 Гэрээт ажилтан | 8.00 | 5.00 |
| 65 | 6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 33.00 | 33.00 |
| 650001 | 6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 12.00 | 11.00 |
| 650009 | 6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 7.00 | 8.00 |

| | | | |
|--------|------------------------------------|------|------|
| 650010 | 6.5.10 Гэрээт ажилтан | 5.00 | 5.00 |
| 650011 | 6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ) | 9.00 | 9.00 |

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Тайлант он |
|------------|---|-----------------|
| 1 | 1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 262,862,022.00 |
| 12 | 1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 262,862,022.00 |
| 122 | 1.1.1.1.1.1 Тусламжийн орлого | 262,862,022.00 |
| 1221 | 1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/ | 262,862,022.00 |
| 12213 | 1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого | 262,862,022.00 |
| 350011 | 1.1.1.1.1.1.1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 7,250,000.00 |
| 350013 | 1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 250,500,000.00 |
| 350014 | 1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 |
| 350015 | 1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,912,022.00 |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 244,777,022.00 |
| 21 | 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 36,277,022.00 |
| 210 | 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 36,277,022.00 |
| 2101 | 1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 857,500.00 |
| 210104 | 1.1.1.2.1.1.1.4 Урамшуулал | 857,500.00 |
| 2102 | 1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 98,612.00 |
| 210201 | 1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал | 98,612.00 |
| 2104 | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 3,940,910.00 |
| 210402 | 1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун | 3,940,910.00 |
| 2106 | 1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 29,880,000.00 |
| 210602 | 1.1.1.2.1.1.6.2 Тавилга | 19,880,000.00 |
| 210604 | 1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар | 10,000,000.00 |
| 2109 | 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 1,500,000.00 |
| 210901 | 1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал | 1,500,000.00 |
| 22 | 1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 208,500,000.00 |
| 2200 | 1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр | 208,500,000.00 |
| 223001 | 1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө | 208,500,000.00 |
| 4 | 1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 18,085,000.00 |
| 5 | 1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (18,085,000.00) |
| 6 | 1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (18,085,000.00) |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь байгууллагын манлайллыг дээшлүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, төрийн албан хаагчдын ёс зүйг чанд сахиж иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн

шуурхай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай
- Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтуудыг 2025.01.01-ээс мөрдөнө.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудитын хүрээнд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Тариалан сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 4 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,575.2 сая төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|----------------|-----------------|----------------|
| Б | 1.0 | 2.0 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 597.2 | 760.9 | 163.7 |
| Авлага | 201.3 | 209.1 | 7.8 |
| Бараа материал | 190.1 | 353.5 | 163.4 |
| Үндсэн хөрөнгө | 3,805.8 | 5,046.1 | 1,240.3 |
| Нийт хөрөнгө | 4,794.4 | 6,369.6 | 1,575.2 |
| Өр төлбөр | 8.5 | 181.4 | 172.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 4,785.9 | 6,188.2 | 1,402.3 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 4,794.4 | 6,369.6 | 1,575.2 |

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 760.9 сая төгрөг болж өмнөх оноос 163.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Төрийн сангийн харилцах | 597.2 | 760.9 | 163.7 |
| Дүн | 597.2 | 760.9 | 163.7 |

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 163.7 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 398.4 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 238.8 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн дансанд 123.6 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 201.3 сая төгрөгөөс эцсийн үлдэгдэл 209.1 сая төгрөг болж 7.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Байгууллагаас авах авлага | 0.0 | 18.0 | 18.0 |
| Татвар, НДШ-ын авлага | 0.0 | 5.5 | 5.5 |
| Зээлийн авлага | 201.1 | 185.1 | -16.0 |
| Зээлийн хүүгийн авлага | 0.2 | 0.5 | 0.3 |
| Дүн | 201.3 | 209.1 | 7.8 |

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өсөхөд Засаг даргын тамгын газрын байгууллагаас авах авах авлага 23.5 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 190.1 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 353.5 сая төгрөг болж 163.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бичиг хэргийн материал | 2.6 | 0.9 | -1.7 |
| Аж ахуйн материал | 24.6 | 118.1 | 93.5 |
| Бусад хангамжийн материал | 147.9 | 217.2 | 69.3 |
| Сэлбэг хэрэгсэл | 7.0 | 5.3 | -1.7 |
| Мал амьтад | 8.0 | 12.0 | 4.0 |
| Дүн | 190.1 | 353.5 | 163.4 |

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засаг даргын тамгын газрын аж ахуйн материал, бусад хангамжийн материал, мал амьтадын үлдэгдэл 163.4 сая төгрөгөөр өссөн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,805.8 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 5,046.1 сая төгрөг болж 1,430.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Барилга, байгууламж, орон сууц | 1,863.9 | 1,926.4 | 62.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | -225.7 | -302.9 | -77.2 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 469.7 | 467.8 | -1.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | -110.7 | -161.2 | -50.4 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 367.6 | 371.2 | 3.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | -155.3 | -176.0 | -20.7 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 62.4 | 90.0 | 27.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | -43.6 | -44.5 | -0.9 |
| Зам, гүүрийн байгууламж | 197.2 | 197.2 | - |
| Хуримтлагдсан элэгдэл | -197.2 | -197.2 | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 1,129.1 | 2,560.0 | 1,430.8 |
| Хуримтлагдсан элэгдэл | -441.4 | -579.4 | -138.0 |
| Ном | 0.06 | 0.06 | 0.0 |
| Программ хангамж | 2.0 | 7.0 | 5.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | -2.0 | -2.0 | - |
| Бусад биет бус хөрөнгө | 913.7 | 913.7 | - |
| Хуримтлагдсан элэгдэл | -24.0 | -24.0 | - |
| Дүн | 3,805.8 | 5,046.1 | 1,240.3 |

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,046.1 сая төгрөг болж 1,240.3 сая төгрөгөөр өссөн нь барилга байгууламж 69.5 сая, бусад үндсэн хөрөнгө 1,456.9 сая, тавилга эд хогшил 32.2 сая, машин тоног төхөөрөмж 28.7 сая, программ хангамж 5.0 сая, нийт 1,592.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 65.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 351.9 сая төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 8.5 сая төгрөг байснаас 172.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - |
|----------------------------------|----------------|-----------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Ажилчидтай холбоотой өглөг | 0.0 | 11.9 | 11.9 |
| Байгууллагад төлөх өглөг | 8.5 | 144.3 | 135.8 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.0 | 9.2 | 9.2 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 0.0 | 16.0 | 16.0 |
| Дүн | 8.5 | 181.4 | 172.9 |

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 181.4 сая төгрөг болж өссөн нь харьяа байгууллагын тогтмол зардлын өр 102.0 сая, Засаг даргын тамгын газрын өр 37.4 сая, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувь хүмүүст төлөх өглөг 7.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэнээс шалтгаалжээ.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,785.8 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 6,188.2 сая төгрөг болж 1,402.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Засгийн газрын хувь оролцоо

| /Сая төгрөг/ | | | |
|---|----------------|-----------------|------------------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 350.6 | 350.6 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 4,126.2 | 5,531.8 | 1,405.6 |
| Өмнөх үеийн үр дүн | 2,955.4 | 4,129.5 | 1,174.1 |
| Тайлант үеийн үр дүн | 1,170.8 | 1,402.3 | 231.5 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 309.0 | 305.8 | (3.2) |
| Дүн | 4,785.8 | 6,188.2 | 1,402.4 |

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,188.2 сая төгрөг болж 1,402.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 940.7 сая, татварын бус орлого 444.2 сая, тусламж санхүүжилтийн орлого 1,373.2 сая, нийт 2,758.1 сая төгрөгийн үйл орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1.6 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Тариалан сумын Засаг даргын тамгын газар:

Мал тооллогын урамшууллын зардлаас 0.9 сая, 2025 оны 07 дугаар сарын цалингаас 1 ажилтны 0.7 сая, нийт 1.6 сая төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгасан боловч, тайлангаар илэрхийлэгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.1 дэх заалтад "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй нь Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул зөвлөмж өглөө.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн Тариалан сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай 5/1 дүгээр тогтоолд зааснаар Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 908.0 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 940.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 103.6 хувиар биелүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,154.9 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 50.0 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 779.3 сая, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 49.2 сая, татварын болон татварын бус орлогоос 805.2 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн оны эхний үлдэгдлээс 100.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 165.4 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 212.7 сая, нийт 3,316.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн зарлагыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 2/01 дүгээр тогтоолоор 3,316.7 сая төгрөгөөр баталж, 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 5/1 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 315.9 сая төгрөгөөр бууруулан 3,000.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,000.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,040.5 сая төгрөгийг урсгал зардалд, 790.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 170.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 901.9 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 479.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 441.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 397.8 сая төгрөгийг сумын татварын бус орлогоос, 780.1 сая төгрөгийг татварын орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 901.9 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 471.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 444.2 сая төгрөгийн татварын бус орлогоос, 940.7 сая төгрөгийг татварын орлогоос санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,612.5 сая төгрөг буюу 87.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 262.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 244.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4.9 сая, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 0.02 сая,

ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 250.5 сая, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 7.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 18.5 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,608.9 сая төгрөгийн 1 хувь буюу 46.1 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 36.9 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 533.9 сая төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 69.4 сая төгрөгийн 6 мэдээлэл байршуулаагүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлэх талбар байхгүй тул тайланд онд гарсан Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байсанд зөвлөмж өглөө.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 181 мэдээллээс хугацаандаа оруулсан 140, хугацаа хоцроож 14 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Мэдээлэх хугацаа болоогүй 3 мэдээлэл, мэдээлээгүй 24 байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар захирамжаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Үндсэн хуулийн өдөрт зориулсан бөхийн барилдааны шагналын зардалд 0.5 сая, 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 18 дугаар захирамжаар “Марш тактик”-ын тэмцээн зохион байгуулахад 0.5 сая, нийт 1.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 46.7 дахь хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.8 дахь заалтад “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”, Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 88/152 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын хоёрдугаар хэсэгт заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байсанд албан шаардлага өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 81.1 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn систем бүртгэсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-------------|----------|-------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 81.1 | 1 | 81.1 | 100% |
| Нийт дүн | 1 | 81.1 | 1 | 81.1 | 100% |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан бүтэц орон тоонд байхгүй багийн сахиул-4, сантехникч-1, олон нийтийн байцаагч-1, нийт 6 гэрээт ажилтан ажиллуулсан асуудлыг дараачийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 5 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайланг нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа орон нутгийн 1 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгч, 1 байгууллага, 2 санг түүвэрт хамруулсан.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 268.6 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 268.6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 1 зөрчилд зөвлөмж өглөө.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 603.3 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 533.9 сая төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 69.4 сая төгрөгийн 6 мэдээлэл байршуулаагүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлэх талбар байхгүй тул тайланд онд

